



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/117

Бэрх хот

**Ажлын хэсгийг
томилох тухай**

Монгол Улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, “Төсвийн тухай” хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.3 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус хотод 2027 онд “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналын хуудсыг өрхөд хүргүүлж хүлээн авч эрэмбэлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Бахыт (Захирагчийн орлогч)
Гишүүд: Э.Мягмарсүрэн (ЗАА-ны дарга)
П.Янжмаа (ЗАА-ны Санхүүгийн албаны дарга)
Ж.Гэрэлтуяа (ЗАА-ны Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн)
Б.Соёл-Эрдэнэ (ЗАА-ны Архив, бичиг хэргийн эрхлэгч)

2.Саналын хуудсыг эрэмбэлж орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналын нэгдсэн жагсаалтыг Сангийн сайдын 228 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу гарган багийн Иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Н.Бахыт)-т үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧ  Ч.ЭНХЖАВХЛАН

232 601 034